



**ТӨВ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД,
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Аудитын тайлан

*ТАБ-ын Дарга, тэргүүлэх
аудитор*

Л.Жаргалсайхан

И-мэйл:

jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Шинжээч

А.Батлхагва

Утас: 70272248 96011185

G-Мейл: batlhagva617@gmail.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 6-р баг

Төрийн байгууллагуудын 2-р

ордон

2017 оны 3 дугаар сар 25

Цахим хуудас: www.audit.mn

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ТӨВ-2017/201/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын урсгал төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай болон нийцлийн аудит 4200-р стандарт нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын урсгал төсвийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн шинжээч А.Батлхагва хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 25-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 03 дүгээр сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 25-нд Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар “Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжил, хамгаалал, оролцоог дээдлэн ажилладаг, тасралтгүй суралцагч байгууллага байна.” эрхэм зорилгын дор Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар-ийн эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхэлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ.

Тайлант хугацаанд Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, захирамж, шийдвэрүүд болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгон, хууль дээдлэх, үр дүнд чиглэсэн судалгаа мэдээлэл, хяналт үнэлгээг боловсронгуй болгож, хүний эрхэд суурилсан, ёс зүйг эрхэмлэн шударга ёс, ил тод, авлига, хүнд сурталгүй үйлчилгээ, харилцааг төлөвшүүлэх” дэвшүүлэн ажиллажээ.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Солонго цогцолборыг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын бүтэцэд нэгтгэн өөрчлөн зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2016 оны 10 сарын 12 ны А/582 захирамжаараар байгуулагдсан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 9 чиглэлээр 47 эрсдэлтэй асуудалд 47 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 28 хувь буюу 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн шууд захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 275663.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан. Нэмэлтээр хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт 104151.3 мянган төгрөг, аймгийн засаг даргын санхүүжилт 7672.3 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 13861.6 мянган төгрөг, Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 275664.4 мянган төгрөгийг зарцуулж, нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл 125984.4 мянган төгрөгийг захиран зарцуулж батлагдсан төсвийг 12237.5 мянган төгрөгөөр хэмнэснийг төсөвт татан төвлөрүүлснийг мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгээр тайлагнасан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оноос “shilendans.gov.mn” цахим сайтад зохих мэдээллийг оруулсан ба 2016 оны эхлэн цахим сайт өөрчлөлт сайжруулалт хийгдэж мэдээ мэдээллийг цаг тухай бүр нь сайтанд оруулан ажилласан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 9 чиглэлээр 47 эрсдэлтэй асуудалд 47 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 28 хувь буюу 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын урсгал төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан горим сорил нь тус байгууллагын мөнгөн хөрөнгийн нийт зарлагын 100 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Барилгын материалын зардалд 794.0 мянган төгрөгийн аж ахуйн материал бүртгэн тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн: Аж ахуйн материалыг холбогдох стандарт журмын дагуу бүртгэн тайлагнахаар зөвлөмж хүргүүлэв.

2. Тайлант онд иргэн, аж ахуй нэгж байгууллагтай хийсэн түрээсийн гэрээний 2729.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн: Иргэн, аж ахуй нэгж байгууллагтай байгуулсан түрээсийн гэрээний авлагыг барагдуулахаар зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдсан алдаа байхгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын урсгал төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг бус хэмжээний нийт 3523.7 мянган төгрөгийн, алдаа зөрчил илэрсэн байна.Үүнд:

1. Материаллаг бус 3523.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн аудитын газраас өмнөх оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын урсгал төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Урьдчилан тогтоосон материллаг байдлын түвшин 42354.2 мянган төгрөгнөөс материаллаг хэмжээний алдаа нь хэтрээгүй тул зөрчилгүй санал дүгнэлт өгөв.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: ШИНЖЭЭЧ

А.БАТЛХАГВА